



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/01

Дорноговь аймаг, Сайншанд сум

Ажил, албан тушаалын жагсаалт батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 275, 2019 оны 276, 2003 оны 233 дугаар тогтоолууд, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 206 дугаар тушаал, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны Б/123 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын бүтэц, ажил, албан тушаалын жагсаалт, ангилал, зэрэглэлийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх жагсаалтаар батлагдсан ажил, албан тушаалын орон тоонд нийцүүлэн, цалин хөлсийг төсөвлөгдсөн сангаас 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

111010007

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын даргын 2024 оны 19 дугаар сарын 04-ний
өдрийн 1/4 дугаар тушаалын хавсралт

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН АЖИЛ, АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

№	Албан тушаал	Ангилал зэрэглэл	Батлагдсан орон тоо
1	Газрын дарга	T3-10	1
2	Ерөнхий нягтлан бодогч	TУ-8	1
3	Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
4	Албан хэрэг хөтлөлт, архивын асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
5	Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
6	Гэрээт ажилтан		2
Газрын удирдлагын хэлтэс			
7	Газрын удирдлагын хэлтсийн дарга	T3-7	1
8	Газрын кадастр, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	T3-6	1
9	Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
10	Газрын татвар, төлбөр, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
11	Суурь судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
12	Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
13	Газрын даамал	T3-5	16
Барилга, хот байгуулалтын хэлтэс			
14	Хэлтсийн дарга	T3-7	1
15	Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	T3-6	1
16	Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
17	Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
18	Ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
19	Барилгын лабораторийн шинжээч	TУ-6	1
	Нийт		35



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/02

Дорноговь аймаг, Сайншанд сум

Цалин шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2019 оны 275 дугаар тогтоол, 2019 оны 276 дугаар тогтоол, 2019 оны 472 дугаар тогтоол, Улсын их хурлын 2019 оны 21 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 206 дугаар тушаал, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны Б/123 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоож, хавсралтаар баталсугай.
2. Албан тушаалын цалинг төсөвлөгдсөн сангаас 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч / Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

441210009

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын *СМ* оны 01 дугаар сарын 04-ний өдрийн тушаалаар тушаалын хэмжээгт

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН АЛБАН ТУШААЛ,

АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ, ЦАЛИН

№	Овог нэр	Албан тушаалын		Албан тушаал	Үндсэн цалин	Зэрэг дэвийн нэмэгдэл	Нууцын болон ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл	Ур чадвар
		Ангилал	Шатлал						
1	Ц.Баярмаа	T3-7	5	Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга	924456	28%		20%	
2	Н.Оюунгэрэл	T3-7	5	Газрын удирдлагын хэлтсийн дарга	924456	26%	40%	10%	
3	П.Дэлгэрхүү	T3-5	5	Барилгын хариуцсан асуудал ахлах мэргэжилтэн	791532	18%		5%	
4	А.Анхилдөл	T3-6	5	Газрын кадастр, газар өмчлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	853375	22%	30%	10%	
5	Ү.Нарангэрэл	T3-5	4	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	754867		30%	5%	
6	Б.Биралдэлгэр	T3-5	3	Ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалтын кадастр, зураг төсөл хариуцсан мэргэжилтэн	609995			<i>СМ 96 ХЗР 13</i>	
7. Итого		T3-5	5	Газрын дарга	791532	18%	15%	5%	

7				асуудал мэргэжилтэн	хариуцсан				
8	Г.Гэрэнцэцэг	T3-5	2	Инженерийн дэд бүтцийн асуудал мэргэжилтэн	681286				
9	С.Болорчимэг	T3-5	5	Албан хэрэг хөтлөлт, архивын асуудал хариуцсан мэргэжилтэн	663419				
10	Д.Сайнтуяа	TY-8	5	Ерөнхий нягтлан бодогч	797676				20%
11	Б.Жавзанлагам	T3-5	2	Мэдээлэл, технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн	680286				
12	Д.Мядагмаа	T3-5	4	Газрын даамал	754867	10%			5%
13	Ж.Бат-Оргил	T3-5	5	Газрын даамал	791532				5%
14	Т.Золбоо	T3-5	4	Газрын даамал	754867	12%			10%
15	М.Отгонбат	T3-5	1	Газрын даамал	642388				
16	И.Болортуяа	T3-5	4	Газрын даамал	754867				10%
17	Ч.Энхбаатар	T3-5	4	Газрын даамал	754867				
18	Б.Адилбиш	T3-5	3	Газрын даамал	718193				5%
19	Д.Жаргалсайхан	T3-5	3	Газрын даамал	718193				
20	М.Дансмаа	T3-5	1	Газрын даамал	642388				
21	Г.Заяасайхан	T3-5	1	Газрын даамал	642388	28%			20%
22	Б.Лханаажав	T3-5	1	Газрын даамал	642388				
23	Б.Солонг	T3-5	1	Газрын даамал	642388				
24	Г.Батсүх	T3-5	3	Газрын даамал	716193	18%			5%
25	Г.Мунхуу	T3-5	1	Газрын даамал	642388				

26	Б.Дүүриймэл	ТЗ-5	1	Газрын даамал БНУП лабораторийн ТЗ-5 МЭДЭГШ	642388				
27	Ш.Гийдэндэвэрэн	ТЗ-5			642388				
28	Б.Батгэрэл	ТҮ-3					5	10%	
29	Б.Дүүрэнжаргал	ТҮ-6	1	Барилгын лабораторын шинжээч	625965				
30	А.Мөнхтогтох	ТҮ-3	4	Жолооч	543175		5%	20%	

---000---



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 19/03

Дорноговь аймаг, Сайншанд сум

Эд хөрөнгийн тооллого хийх тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 72 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Оюунгэрэл /Газрын удирдлагын хэлтсийн дарга /

Нарийн бичгийн дарга: Б.Батгэрэл / Нярав /

Гишүүд: Д.Сайнтуяа /Ерөнхий нягтлан бодогч/
Ш.Найдансүрэн /Барилгын материалын үйлдвэрлэл,
лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн/
Б.Жавзанпагам /Мэдээллийн технологийн
асуудал хариуцсан мэргэжилтэн/
С.Болорчимэг / Албан хэрэг хөтлөлт, архивын
асуудал хариуцсан мэргэжилтэн/

2. Эд хөрөнгийн тооллого хийх үйл ажиллагааг 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн 2021 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр хүртэл үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц, үр дүнг 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр танилцуулахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

441210001



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/04

Дорноговь аймаг, Сайншанд сум

Лабораторийн хөтөлбөр, төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалт, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага" /MNS ISO/IEC 17025:2018/ стандартыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын дэргэдэх Барилгын материалын лабораторийн менежментийн тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулахад шаардлагатай хөтөлбөр, төлөвлөгөөнүүдийг хавсралтаар баталсугай.

2. Лабораторийн Дотоод аудитын хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, Тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар, Эрсдлийн менежментийн төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар, Лаборатори хоорондын харьцуулалтад оролцох төлөвлөгөөг дөрөвдүгээр хавсралтаар, Дотоод хяналтын төлөвлөгөөг тавдугаар хавсралтаар, Сургалтын төлөвлөгөөг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Лабораторийн хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахыг лабораторийн эрхлэгч /Ш.Найдансүрэн/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

20210013



БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИЙН ДОТООД АУДИТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын материалын лабораторийн үйл ажиллагаа, менежментийн тогтолцооны шаардлагад нийцэж байгаа эсэхэд дотоод аудитыг явуулж, лабораторийн менежментийн тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлж, хадгалахад оршино.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

Дотоод аудит нь лабораторийн үйл ажиллагааны дотоодын хяналтыг хангах

Гурав. Хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2021-2023 онд хэрэгжүүлнэ.

Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт

4.1. Дотоод аудитын үйл ажиллагааг лабораторийн эрхлэгч хариуцан зохион байгуулах ба жилд 1 удаа ГХБХБГ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг дотоод аудитыг хийж, тайлагнана.

4.2. Лабораторийн эрхлэгч нь дотоод аудит явуулах тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулж ГХБХБГ-ын даргаар батлуулж, хэрэгжүүлнэ.

4.3. Дотоод аудитын тайлан нь менежментийн дүн шинжилгээний оролт болно.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. ГХБХБГазар нь лабораторийн дотоод аудитыг хариуцан зохион байгуулах ажилтнуудыг чадавхижуулах, сургаж дадлагажуулах

5.2. Лабораторийн үйл ажиллагаа менежментийн тогтолцооны шаардлагад нийцэж байгааг жил бүр тодорхойлох.

5.3. Дотоод аудитын шалгуур үзүүлэлтийг сайжруулах, нэмж баяжуулах


5.4. Дотоод аудитаар илрэх гажилт, үл тохирлыг багасгах, ижил төстэй үл тохирлыг давтан гаргахгүй байх арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх

Зургаа. Хүрэх үр дүн

Барилгын материалын лабораторийн үйл ажиллагаа нь "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага" /MNS ISO/IEC 17025:2018/ стандартын шаардлагад нийцэж улмаар сорилтын үр дүнгийн чанар хангагдахад нөлөөлнө.

Долоо. Шалгуур үзүүлэлт

Стандартын шаардлагууд, лабораторийн өөрийн бодлого, дүрэм журмын шаардлагууд.



БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИЙН ШАЛГАЛТ ТОХИРУУЛГЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь барилгын материалын лабораторийн багаж хэрэгслэл, тоног төхөөрөмжийг төлөвлөгөөт шалгалт тохируулгад хамруулах, шаардлагатай тохиолдолд үзлэг, хяналт, тохируулга хийх нөхцөлийг бүрдүүлж, сорилтын үр дүнгийн үнэн бодит байдлыг хангуулахад оршино.

Хоёр. Хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2021-2023 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Удирдлага, зохион байгуулалт

- 3.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг лабораторийн эрхлэгч удирдан зохион байгуулна.
- 3.2. Лабораторийн эрхлэгч шалгалт тохируулгын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулж ГХБХБГ-ын даргаар батлуулан, хэрэгжилтийг хангуулна.
- 3.3. Лабораторийн багаж, хэрэгслэл, тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын үйл ажиллагааг лабораторийн шинжээч хариуцан зохион байгуулах ба хэрэгжилтэнд эрхлэгч хяналт тавьж ажиллана.
- 3.4. Хэмжлийн багаж, тоног төхөөрөмжид шалгалт тохируулгыг чадавхитай лабораториор хийлгэнэ.
- 3.5. Лабораторийн эрхлэгч хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргана.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 4.1. Шалгалт тохируулгад хамруулах багаж хэрэгслэл, тоног төхөөрөмжийн бүртгэлтэй байх ба бүртгэлийг шинжээч хөтлөн ажиллана.
- 4.2. Хэт ачаалсан, буруу харьцсан, эвдэрсэн тохиолдолд зохих арга хэмжээг авч, сорилтыг гүйцэтгэхийн өмнө чадавхитай лабораториор шалгалт тохируулга хийлгэнэ.
- 4.3. Шинэ багаж, хэрэгслэл, тоног төхөөрөмжийг ашиглахын өмнө чадавхитай лабораториор шалгалт тохируулга хийлгэх шаардлагатай.

Тав. Хүрэх үр дүн

Барилгын материалын лабораторийн шалгалт тохируулгын үйл ажиллагаа нь сорилтын үр дүнгийн чанар хангагдахад нөлөөлнө.

Зургаа. Шалгуур үзүүлэлт

Эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлсэн шалгалт тохируулгын хэмжлийн эргэлзээ, өргөтгөсөн эргэлзээний өөрчлөлтийн утга.



**БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИЙН ЭРСДЭЛИЙН
МЕНЕЖМЕНТИЙН 2 ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Эрсдэл		Шийдвэрлэх арга хэмжээ
1	Ажилтантай холбоотой эрсдэл	Ажилтны мэдлэг боловсрол, ур чадвар сул байх	Менежментийн тогтолцооны баримт бичиг, Чанарын гарын авлага, лабораторийн дүрэм, журмыг танилцуулах Ажилтны журмын дагуу сургах, хяналт тавих, ур чадварт хяналт үнэлгээ хийх БХТ-ийн БМСШЛ болон өөр бусад чадавхитай лабораторид дагалдуулан сургах MNS ISO/IEC 17025:2018 стандартын холбогдох сургалтуудад хамруулах Ажлын байран дээр дагалдуулан сургах, сорилт, шинжилгээний стандартыг бүрэн судлуулах, дотоод сургалт зохион байгуулах
2	Тоног төхөөрөмжтэй холбоотой эрсдэл	Эвдрэл, гэмтэл гарах	Үйл ажиллагааг зогсоож, учир шалтгааныг судлан тогтоох Тоног төхөөрөмжид засвар үйлчилгээг хийлгэх Дотоод шалгалтыг хийх, шаардлагатай тохиолдолд шалгалт тохируулгыг чадавхитай байгууллагаар хийлгэх
3	Хүсэлт, гэрээний шинжилгээтэй холбоотой эрсдэл	Сорилт хийлгэх шаардлагыг буруу ойлгох Хэрэглэгчтэй харилцан уялдаа холбоогүй байх	Лабораторийн эрхлэгч нь хэрэглэгчийн ирүүлсэн хүсэлтэд дүн шинжилгээг хийж, ойлгомжгүй, эргэлзээтэй, алдаатай гэж үзсэн тохиолдолд дахин дэлгэрэнгүй мэдээллийг хэрэглэгчээс авах, тодруулах арга хэмжээг авах Сорилтын арга, хугацаа зэрэг шаардлагатай мэдээллийг хэрэглэгчид тодорхой тайлбарлан өгөх, мэдээллийн самбарт байршуулах
4	Тайлантай холбоотой эрсдэл	Буруу ба зохисгүй тайлан	Лабораторийн эрхлэгч сорилт шинжилгээг хянаж, сорилтын тайланг хэвлэн гаргах, буруу тайлан хэрэглэгчид очсон тохиолдолд нэн даруй мэдэгдэж, тайланг татан авч, залруулах арга хэмжээг авах
5	Үл тохирох ажилтай холбоотой эрсдэл	Үүнийг арилгахгүй, засварлахгүй, давтах	Үл тохирох ажил илэрсэн тохиолдолд журмын дагуу зохих арга хэмжээг авах, учир шалтгааныг нь тодорхойлсны дараа залруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх

Боловсруулсан:

Лабораторийн эрхлэгч

/Ш.Найдансүрэн/

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
даргын 2021 оны .01 дүгээр сарын .07-ны өдрийн
А/0.4 тоот тушаалын 4 дүгээр хавсралт

**ЛАБОРАТОРИ ХООРОНДЫН ХАРЬЦУУЛАЛТАНД ОРОЛЦОХ
2 ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/Д	Сорилтын түүхий эдийн төрөл	Стандарт	Д/Дугаар:
2021 он			
1	Хөөсөн полистрол хавтан	Барилгын дулаан тусгаарлах материал-нягт тодорхойлох арга, MNS ISO 29470:2010, Ус шингээлт тодорхойлох MNS ISO 29767:2010,	ГХ-РО-01/2021
2	Тоосго	Физик механик шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлох MNS 0982:1980, MNS 0983:1980	ГХ-Br-01/2021
3	Элс	Физик механик шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлох MNS 2916:2014	ГХ-Sa-01/2021
2022 он			
1	Хөөсөн полистрол хавтан	Барилгын дулаан тусгаарлах материал-нягт тодорхойлох арга, MNS ISO 29470:2010, Ус шингээлт тодорхойлох MNS ISO 29767:2010,	ГХ-РО-01/2022
2	Портландцемент	Цемент-олон ширхэглэлтэй стандарт элс хэрэглэн турших арга, MNS 0976:2008	ГХ-CE-01/2022
3	Явган зам талбайн хавтан	Физик механик шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлох	ГХ-Ti-01/2022

Оролцох лабораторийн тоо: 3


Тайлбар: БХТ-ийн Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори,
Барилга Архитектурын корпорацийн лаборатори, болон бусадтай итгэмжлэгдсэн улсын
болон хувийн лаборатори хоорондын харьцуулалтад орохоор төлөвлөсөн болно.

Боловсруулсан:

Лабораторийн эрхлэгч

/Ш.Найдансүрэн/

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
даргын 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн
А/0.4 тоот тушаалын 5 дугаар хавсралт



**БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИЙН ДОТООД
ХЯНАЛТЫН 2 ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Сорилтын зүйл	Тоо хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1	Пикнометрийн аргаар болон Ле Шатальен багажаар нягт тодорхойлох	Элс	1	2021-03 2022-03	Лабораторийн эрхлэгч
2		Дайрга	1		
3	Хадгалагдаж буй дээжид сорилтыг давтан хийлгэх	Элс	1	2021-08 2022-08	
4		Тоосго	1		
5		Хөөсөн полистрол хавтан	1		
6	Үл мэдэгдэх дээжид сорилт гүйцэтгүүлэх	Тухайн жилд ирсэн дээжинд	1	2021-11 2022-11	
7		Тухайн жилд ирсэн дээжинд	1		
8	Тоног төхөөрөмжид хяналт шалгалт хийх	Хатаах шүүгээ	5 удаа сар бүр	2021-05 2022-05	Шинжээч
9		Аналитик жин	7 удаа сар бүр	2021-04 2022-04	
10		Гидро статик жин	4 удаа сар бүр	2021-06 2022-06	
11	Сорилтын үр дүнд дүн шинжилгээ хийх	-	Тухай бүр		Лабораторийн эрхлэгч, шинжээч
12	Шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх	-	Тухай бүр		

Боловсруулсан:

Лабораторийн эрхлэгч

/Ш.Найдансүрэн/

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
даргын 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн
А/04 тоот тушаалын 6 дугаар хавсралт



**БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИЙН
2 ЖИЛИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/Д	Сургалтын сэдэв	Хугацаа	Хамрагдах ажилтны тоо
2021 он			
1	БХТ-ийн БМСШЛ болон өөр итгэмжлэгдсэн лабораторид дагалдуулан сургах сургалт	2-р улирал	1
2	"Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавигдах шаардлага MNS ISO/IEC 17025:2018" стандарт болон бусад холбогдох стандартуудын сургалт	Зарлагдсан хугацаанд	1
3	"Хэмжлийн эргэлзээг тооцох нь" сэдэвт сургалт	Зарлагдсан хугацаанд	1
4	Ажлын байран дээрх сургалт	Тухай бүр	2
5	Сорилт, шинжилгээний стандарт судлах дотоод сургалт	Тухай бүр	2
6	Байгууллагын дотоод сургалт	Тухай бүр	2
7	Бусад байгууллагуудаас зохион байгуулж буй сургалт	Тухай бүр	2
2022 он			
1	БХТ-ийн БМСШЛ болон өөр итгэмжлэгдсэн лабораторид дагалдуулан сургах сургалт	2-р улирал	1
2	"Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавигдах шаардлага MNS ISO/IEC 17025:2018" стандарт болон бусад холбогдох стандартуудын сургалт	Зарлагдсан хугацаанд	2
3	"Хэмжлийн эргэлзээг тооцох нь" сэдэвт сургалт	Зарлагдсан хугацаанд	1
4	Ажлын байран дээрх сургалт	Тухай бүр	2
5	Сорилт, шинжилгээний стандарт судлах	Тухай бүр	2
6	Байгууллагын дотоод сургалт	Тухай бүр	2
7	Бусад байгууллагуудаас зохион байгуулж буй сургалт	Тухай бүр	2

Боловсруулсан:

Лабораторийн эрхлэгч:

/Ш.Найдансүрэн/



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 05

Дорноговь аймаг, Сийнтманд сум

Ээлжийн амралтын хуваарь батлах тухай

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.6 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын албан хаагчдын 2021 оны ээлжийн амралтын хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан хуваарийн дагуу ээлжийн амралтаа эдэлж, ээлжийн амралттай байх хугацаанд орлон ажиллах албан хаагчид ажлаа хүлээлгэн өгөхийг нийт албан хаагчдад даалгасугай.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

441210026



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭЖҮҮЛЭГЧ АГЕНЦЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 11/06

Дорноговь аймаг, Сайншанд сум

Г

З

Ажил хүлээлцүүлэх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйл, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Эрдэнэ сумын газрын даамал Бат-Эрдэнийн Солонгын ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Энхбат	Геоземи, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн /
Гишүүн: У.Баярсайхан	Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн /
Б.Жавзанпагам	Мэдээлэл, технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн /
Б.Батгэрэл	Нярав /

2. Б.Солонгын ажлыг 2020 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн дотор хүлээлцэж дуусгахыг ажлын хэсгийн ахлагч / Х.Энхбат /-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН



ДӨРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 11/07

Дорноговь аймаг, Сайншүүр сум

Г

Г

Ажил хүлээлцүүлэх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйл, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн Үнэнбатын Нарангэрэлээс Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ухнын Баярсайхан, Суурь судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн Олзвойн Оюунцэцэг нарт ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Энхбат

/Геодези, зураг зүйн асуудал хариуцсан
мэргэжилтэн /

Гишүүн: А.Анхилдөл

/Газар өмчлөл, газрын кадастрын
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /

Б.Жавзанпагам

/Мэдээлэл, технологийн асуудал
хариуцсан мэргэжилтэн/

Б.Батгэрэл

/ Нярав/

2. Ү.Нарангэрэлээс У.Баярсайхан, О.Оюунцэцэг нарт ажлыг 2020 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн дотор хүлээлцэж дуусгахыг ажлын хэсгийн ахлагч / Х.Энхбат /-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

441210023
D:/2020/тушаал-A.doc



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 18 өдөр

Дутаар 8/08

Дорноговь аймаг, Сайншанд сум

Ажил хүлээлцүүлэх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйл, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Улаанбадрах сумын газрын даамал Гантемөрийн Очирсүхэд ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Энхбат

/Геодези, зураг зүйн асуудал хариуцсан
мэргэжилтэн /

Гишүүн: У.Баярсайхан

/ Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн
асуудал хариуцсан мэргэжилтэн /

Б.Жавзанпагам

/Мэдээлэл, технологийн асуудал
хариуцсан мэргэжилтэн/

Б.Батгэрэл

/ Нярав/

2. Г.Очирсүхэд ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн дотор хүлээлцэж дуусгахыг ажлын хэсгийн ахлагч / Х.Энхбат /-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

111210056



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 0109

Дорноговь аймаг, Сийншанд сум

Ажил хүлээлцүүлэх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйл, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Эрдэнэ сумын газрын даамлаар Санзайн Батбаярт ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Энхбат

/Геодези, зураг зүйн асуудал хариуцсан
мэргэжилтэн /

Гишүүн: У.Баярсайхан

/ Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн
асуудал хариуцсан мэргэжилтэн /

Б.Жавзанпагам

/Мэдээлэл, технологийн асуудал
хариуцсан мэргэжилтэн/

Б.Батгэрэл

/ Нярав/

2. С.Батбаярт ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн дотор хүлээлцэж дуусгахыг ажлын хэсгийн ахлагч / Х.Энхбат /-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

111010049



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 07/10

Дорноговь аймаг, Сайншант сум

Тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.5.1 дэх заалт, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын нярав Басбишийн Батгэрэлийн төрсөн эх нас барсан тул байгууллагаас тэтгэмж олгосугай.

2. Дээрх тэтгэмжид шаардагдах 180 000 / нэг зуун наян мянга / төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

11010063



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 11/11

Дорноговь аймаг, Сайншанд сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор албан хаагчдад гар ариутгагч худалдан авахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 180000 / нэг зуун наян мянга / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

11010065



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 7/Н

Дорноговь аймаг, Сайншалан сум

┌ Сургалтын зардал гаргах тухай ─┐

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаал, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн Паашкагийн Дэлгэрхүүгийн мэргэшсэн төсөвчний сургалтанд хамрагдахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 225000 / хоёр зуун хорин таван мянга / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

111010071



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 01/13

Дорноговь аймаг, Сайншанд сум

Хүндэтгэл үзүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 14.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол үндэстний уламжлалт баяр хаврын тэргүүн сарын шинийн нэгэн буюу Төмөр цагаан үхэр жилийн сар шинийн баярыг тохиолдуулан байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлсүгэй.
2. Хүндэтгэл үзүүлэх ахмадын нэрс, зардлын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Дээрх арга хэмжээнд шаардагдах 690000 /зургаан зуун ерэн мянга/ төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

202102073

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын даргын 2001 оны 02 дугаар сарын 08-ний
өдрийн 4/3 дугаар тушаалын хавсралт



ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ АХМАДЫН НЭРС, ЗАРДЛЫН ТООЦОО

№	Овог нэр	Алтан тушаал	Регистрийн дугаар	Мөнгөн дүн
1	С.Мөнхцэцэг	Ахмад настан	ЕЮ59041408	150,000
2	Г.Лхамсүрэн	Ахмад настан	ЕЕ50041613	150,000
3	Х.Оюунчимэг	Ахмад настан	ЕС60050201	150,000
4	Ч.Дүгэрсүрэн	Ахмад настан	ЕЮ53031511	150,000
	Гарын бэлэг			90,000
	Нийт			690,000

---oOo---



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 9/14

Дорноговь аймаг, Сайнтаанд сум

Гэрээ цуцалж, чөлөөлөх тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Иргэний хуулийн 364 дүгээр зүйлийн 364.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын гэрээт ажилтан С.Шинэбаяртай байгуулсан гэрээг 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөр тасалбар болгон цуцалж, чөлөөлсүгэй.

2. С.Шинэбаяртай холбогдох тооцоог хийж дуусгахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/15

Дорноговь аймаг, Сайншанд сум

Сургалтын зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаал, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн Паашкагийн Дэлгэрхүү, Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Сэрдамбын Гэрэлцэцэг, Барилгын материалын лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн Шархүүгийн Найдансүрэн нар нь АЗ сертификатын сургалтанд хамрагдахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 210000 / хоёр зуун арван мянга / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

11010067



ДОРНОГОВЬ-АЙМГИЙН ТАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 4/16

Дорноговь аймаг, Сайнманд сум

Сургалтын зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаал, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн Батмөнхийн Билэгдэлгэр, Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Сэрдамбын Гэрэлцэцэг, Барилгын материалын лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн Шархүүгийн Найдансүрэн нарыг төсөвчний анхан шатны сургалтанд хамрагдахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 690000 / зургаан зуун ерэн мянга / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

11010069



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/17

Дорноговь аймаг, Сайншанд сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, ажлын цаг ашиглалтыг сайжруулах хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор цаг бүртгэлийн төхөөрөмж авахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 325000 / гурван зуун хорин таван мянган / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/- д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

202102088



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 8/18

Дорноговь аймаг, Сайншанд сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, мэргэжлийн ур чадварыг сайжруулах, мэдээллээр хангах зорилгоор барилгын сэтгүүл худалдан авахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 161500 / нэг зуун жаран нэгэн мянга таван зуун / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

111111190



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 4/19

Дорноговь аймаг, Сайншазд сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн Залбан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор сэтгүүлийн ширээ худалдан авахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 160000 / нэг зуун жаран мянган/ төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

11010092



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/00

Дорноговь аймаг, Сайншанд сум

**Эрхийн гэрчилгээг хүчингүй
болгох тухай**

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 тоот тушаалаар баталсан "Газар эзэмших, ашиглах гэрчилгээ олгох журам"-ын 15.12, 15.13 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Бичилт хийх албан тушаалтны буруугаас ашиглах боломжгүй болсон Аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглах эрхийн 000001525, 000001524, 000001522, 000002634, Аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн 000002959, 0000002910-000002915, 000008148-000008172, 000008196, 000008070, Иргэний газар эзэмших эрхийн 000056253, 000021773, 000065643, 000065646, 000065811, 000065813, 000065816, 000065935, 000065943, 000065947, 000065949, 000066086, 000066094, 00006610, 000066127, 000066136, 000065914, 000066146, 000064980, 000066178, 000066300, 000065429, Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн 000002928, 000002929 дугаар бүхий эрхийн гэрчилгээнүүдийг хүчингүй болсонд тооцсугай.

2. Дээрх хүчингүй болсон эрхийн гэрчилгээнүүдийн үнийг холбогдох журмын дагуу буруу бичилт хийсэн албан тушаалтнаар төлүүлэхийг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/, нярав /Б.Батгэрэл/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 1/21

Дорноговь аймаг, Сайншанд сум

**Захиалагчийн техник хяналтыг
хэрэгжүүлэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах заалт, Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.9 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 170 дугаар тогтоолоор баталсан Барилгын ажлын захиалагчийн дүрмийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улс, орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх явцад гүйцэтгэх ажлын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт, хариуцах инженерийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Захиалагчийн техник хяналтыг холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, төрийн албан хаагчийн ёс зүйг чанд баримтлан ажиллахыг хариуцсан инженерүүдэд даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын хэлтэс /Ц.Баярмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

11010097



Аймгийн ГХБХБТ-ын даргын 2021 оны
44 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт

ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИК ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦАД ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

1. Батлагдсан зураг төсөл, техникийн баримт бичигтэй танилцах
2. Үе шатны хяналтыг батлагдсан зураг төсөл, БНБД-ийн дагуу хэрэгжүүлэх
3. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ хяналтын хуудас тогтмол хөтлөх
4. Барилгын ажлын явцын мэдээ тайланг гаргах, байгууллагын вэбсайт болон пейж хуудсанд барилгын хяналт шалгалттай холбоотой мэдээлэл бэлтгэж оруулах
5. Барилга угсралт, их засварын ажлын явцад илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгуулах, талбайн журналд шаардлага зөвлөмжийг хяналт хийх бүрд тодорхой бичиж тэмдэглэн биелэлтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэгчид албан бичгээр шаардлага, зөвлөмж хүргүүлэх
1. Замын-Үүд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар эзэмшигч иргэн Чулуунбат овогтой Уранцэцэг /ЕЮ74011009/ нь 0283551 тоот "Газар эзэмших эрхийн гэрчилгээ"-г гэж үрэгдүүлсэн тул дээрх тоот эрхийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

2. Дээрх хүчингүй болсон эрхийн гэрчилгээний талаархи мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж, олон нийтэд хүргэхийг Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн /Б.Жавзанпагам/-д, газар эзэмшигчид газар эзэмших эрхийн гэрчилгээ нөхөж олгохыг Замын-Үүд сумын газрын даамал /Ж.Бат-Оргил/-д үүрэг болгосугай

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

441210197



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/48

Дорноговь аймаг, Сайванд сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор бичиг хэргийн материал авахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 1000000 / нэг сая / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

441010317



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 4/49

Дорноговь аймаг, Сайншанд сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, ажлын бүтээмжийг сайжруулах, техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдал, аюулгүй байдлыг хангах зорилгоор авто машины сэлбэг авахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 1055600 / нэг сая тавин таван мянга зургаан зуу / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

441210218

Аймгийн ГХБХБГ-ын даргын
2021 оны 6 сарын 23-ны өдрийн
1/49 тоот тушаалын хавсралт

**Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай сэлбэг хэрэгслийн
зардлын тооцоо**

Д/Д	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бензин насос	2	33,000	66,000
2	Бензин насос	2	55,000	110,000
3	Өндөрлөгөө	4	8,900	35,600
4	Салон өнгөлөгч	1	10,000	10,000
5	Шилний шингэн	2	6,950	13,900
6	Амортизатор	4	71,500	286,000
7	Шил арчигч	4	5,000	20,000
8	Өндгөн тулгуур	2	28,000	56,000
9	Тэвшний тулк	2	33,000	66,000
10	Масло	1	52,000	52,000
11	Маслын шүүр	1	8,000	8,000
12	Ажлын хөлс	1	110,000	110,000
13	Агаар шүүгч	1	22,000	22,000
14	Агаар шүүгч/дотор/.	1	7,100	7,100
15	Шалавч	1	55,000	55,000
16	Масло	6	13,500	81,000
17	Карбидатор цэвэрлэгч	2	4,500	9,000
18	Ажлын хөлс	1	30,000	30,000
19	Карбидатор цэвэрлэгч	2	9,000	18,000
	Нийт дүн		562,450.00	1,055,600.00



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/50

Дорноговь аймаг, Сайншанд сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, ажлын бүтээмжийг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд сурталчилах, мэдээ мэдээллээр хангахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 1200000 / нэг сая хоёр зуун мянга / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

441210220

Аймгийн ГХБХБГ-ын даргын
2021 оны 06 сарын 22-ны өдрийн
.../50 тоот тушаалын хавсралт

**Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай мэдээлэл сурталчилгааны
зардлын тооцоо**

Д/Д	Зардлын төрөл	/сар/	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Зар мэдээний төлбөр	3	400,000	1,200,000
	Нийт дүн		400,000.00	1,200,000.00



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/БТ

Дорноговь аймаг, Сайншанд сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор Барилгын хэлтсийн дарга Ц.Баярмаагийн албан хэрэгцээнд компьютер худалдан авахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 4149800 /дөрвөн сая нэг зуун дөчин есөн мянга найман зуу / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

641210322

Аймгийн ХБХБГ-ын даргын
2021 оны 11 сарын 11-ны өдрийн
4/58 тоот тушаалын хавсралт



Барилга, хот байгуулалтын хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмжийн зардал

Д/Д	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Dell i7-10700 8 gb/суурин/	1	3,449,800.00	3,449,800.00
2	Дэлгэц/dell P2719H/	1	700,000	700,000.00
				-
				-
	Нийт дүн		4,149,800.00	4,149,800.00



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/58

Дорноговь аймаг, Сайншанд сум

Сургалтын зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Барилгын материалын лабораторийн шинжээч Эрдэнэбилэгийн Эрхтөр нь MNS: ISO/IEC 17025:2013 "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага" сэдэвт сургалтанд хамрагдах болсон тул шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 90000 / ерэн мянган/ төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

441810230



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

№ 011 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/59

Дорноговь аймаг, Сайтшанд сум

**Өмч хамгаалах байнгын зөвлөл
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Ц.Баярмаа /Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга/

Гишүүд: С.Сэргэлэнбаатар /Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

Х.Энхбат /Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн/

Д.Сайнтуяа /Ахлах нягтлан бодогч/

Б.Батгэрэл /Нярав/

2. Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтанд байнгын хяналт тавьж, үр дүнг хагас, бүтэн жилээр гарган танилцуулахыг Зөвлөлийн дарга /Ц.Баярмаад/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

441210734



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/60

Дорноговь аймаг, Сайншанд сум

Эд хөрөнгийн тооллого хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 72 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн дарга: У.Баярсайхан /Газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн/

Нарийн бичгийн дарга: Б.Батгэрэл /Нярав /

Гишүүд: Д.Сайнтуяа /Ерөнхий нягтлан бодогч/

Ш.Найдансүрэн /Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

Б.Жавзанпагам /Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

С.Болорчимэг /Албан хэрэг хөтлөлт, архивын асуудал хариуцсан мэргэжилтэн/

Эд хөрөнгийн тооллого хийх үйл ажиллагааг 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр хүртэл үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц, үр дүнг 2021 оны 07 дугаар сарын 5-ны өдөр танилцуулахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

441210232



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/61

Дорноговь аймаг, Сайншанд сум

**Эрхийн гэрчилгээ хүчингүй
болгох тухай**

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах гэрчилгээ олгох журам"-ын 10.17 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Сайншанд сумын 8 дугаар багийн нутаг дэвсгэрт Үзүүр-2 гудамжны 221 тоот гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар эзэмшигч иргэн Батчулуу овогтой Сосорбурам /ЕЕ85071810/ нь 0245474 тоот "Газар эзэмших эрхийн гэрчилгээ"-г гэж үрэгдүүлсэн тул дээрх тоот эрхийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

2. Дээрх хүчингүй болсон эрхийн гэрчилгээний талаархи мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж, олон нийтэд хүргэхийг Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн /Б.Жавзанпагам/-д, газар эзэмшигчид газар эзэмших эрхийн гэрчилгээ нөхөж олгохыг Сайншанд сумын газрын даамал /Д.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

441210241



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2081 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 3/62

Дорноговь аймаг, Сайншанд сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор автомашины сэлбэг, хэрэгсэл худалдан авахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 561000 / таван зуун жаран нэгэн мянган / төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

441310250

Аймгийн ГХБХБГ-ын даргын
2021 оны 27 сарын 21-ны өдрийн
462 тоот тушаалын хавсралт

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай сэлбэг хэрэгслийн
зардлын тооцоо

Д/Д	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бензин насос	1	495,000	495,000
2	Тунгаагуур	1	66,000	66,000
	Нийт дүн		561,000.00	561,000.00



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/8

Дорноговь аймаг, Сайвшаал сум

Г Лабораторийн шинжилгээний стандарт
ажлын зааварчилгааг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаан, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалт, "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага" /MNS ISO/IEC 17025:2018/ стандарт, шинжилгээний аргын стандартууд, лабораторийн Чанарын гарын авлагыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилгын материалын лабораторийн сорилтын үр дүнгийн үнэн бодит байдлыг хангуулахад шаардлагатай стандарт ажлын зааварчилгааг хавсралтаар баталж лабораторийн сорилт шинжилгээний үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажилласугай.

2. Элсний шинжилгээний стандарт ажлын зааварчилгааг /CA3-1/-ыг 1 дүгээр хавсралтаар, Дайрганы шинжилгээний стандарт ажлын зааварчилгааг /CA3-2/-ыг 2 дугаар хавсралтаар, Тоосгоны шинжилгээний стандарт ажлын зааварчилгааг /CA3-3/-ыг 3 дугаар хавсралтаар, Бетон сорьцын шинжилгээний стандарт ажлын зааварчилгааг /CA3-4/-ыг 4 дүгээр хавсралтаар, Хөөсөн полистрол хавтангийн шинжилгээний стандарт ажлын зааварчилгааг /CA3-5/-ыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/04 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

441010270



ХӨӨСӨН ПОЛИСТРОЛ ХАВТАНГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ СТАНДАРТ АЖЛЫН ЗААВАРЧИЛГАА

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандарт ажлын зааварчилгаа /CAЗ/ нь барилгад хэрэглэх үйлдвэрийн аргаар боловсруулсан бүрээсэн өнгөлгөөтэй ба өнгөлгөөгүй хөөсөн полистирол EPS, XPS бүтээгдэхүүнд хамаарна.

2. НОРМАТИВ ИШ ТАТАЛТ

- MNS ISO 29470:2010 Барилгын дулаан тусгаарлах материал - Нягтыг тодорхойлох арга.
- MNS ISO 29466:2010 Барилгын дулаан тусгаарлах материал-зузааны хэмжээг тодорхойлох арга.
- MNS ISO 29767:2010 – Барилгын дулаан тусгаарлах материал-богино хугацаанд бүрэн бус живүүлэх үеийн ус шингээлтийг тодорхойлох арга

3. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

- XMTS-6000 маркийн хатаах шүүгээ
- 0.01г нарийвчлалтай жин
- 0.1г нарийвчлалтай жин
- Штангенциркуль
- Алчуур

4. СОРИЛТ ГҮЙЦЭТГЭХ ДАРААЛАЛ

4.1 Дээж бэлтгэх:

1м² –аас багагүй дээж авах ба сорьцыг бэлтгэхдээ дээжээс 5х5х5 см хэмжээтэй 5-аас цөөнгүй сорьц аван сорьцуудаа дараалуулан дугаарлаж тэмдэглэнэ. Мөн ус шингээлтийг тодорхойлоход зориулж 200х200мм хэмжээтэй 4 ширхэг дээж бэлдэнэ.

Бэлдсэн дээжээс урт (а), өргөн (b), өндөр (с) гэсэн 3 хэмжээсийг авч тус бүрийн эзлэхүүнийг бодож нийт сорьцуудын дундажаар тодорхойлно.

Бэлдсэн сорьцуудаа хатаах шүүгээнд хийж асаах ОН улаан товчлуурыг дарж градусыг /60°C/ тохируулан /high temperature/ товчлуурыг бас ажиллуулан тогтмол жинтэй болтол хатаана. Нэг удаа хатаахдаа 2 цагаас багагүй хугацаанд хатааж 30 минутаас багагүй хугацаанд хөргөн 0,01 г-ын нарийвчлалтай жин дээр жинлэн тэмдэглэнэ. (m_{const})

1м² бүхий дээжин дээрээ 4 өөр газарт зузааныг нь хэмжиж үр дүнг нь нийт хэмжилтийн дундажаар тооцно.

4.2 Нягтыг тодорхойлох:

Тогтмол жинтэй болтол хатаасан дээжийн дундаж жинг эзлэхүүнд нь харьцуулсан харьцаагаар тодорхойлно.

$$\rho = \frac{m_{const}}{V} \quad (\text{кг/м}^3)$$

V- сорьц тус бүрийн дундаж эзлэхүүн.

m-сорьцын жин, кг

4.3 Ус шингээлт:

Сорьцыг богино хугацаанд бүрэн бус живүүлэх үеийн ус шингээлтийг тодорхойлно. Сорьцын доод хэсгийг 24 цаг усанд байлгасны дараах жингийн өөрчлөлтийг хэмжинэ. Усны температур (23±5)°C байна.

А арга (чөлөөт усыг урсган зайлуулах)

Сорьцын зузаан нь бүтээгдэхүүний зузаантай адил байна. Сорьц нь дөрвөлжин хэлбэртэй /200±1/мм хэмжээтэй 4-өөс цөөнгүй дээж байна. Сорьцыг (23±5)°C -ийн температуртай орчинд 6-аас багагүй цаг хадгалж, туршилтыг (23±5)°C -ийн температуртай орчинд явуулна. Сорьцын анхны жин m_0 -г 0.1г-ийн нарийвчлалтайгаар тодорхойлно. Туршилт явуулахдаа ус шингээлт хийх савандаа нийт сорьцын хагасыг хамгийн их талбайтай гадаргууг дээш нь, үлдсэн хагасыг нь мөн доош нь харуулан байрлуулсаны дараагаар саванд усыг хийхдээ сорьцын улнаас усны түвшин хүртэлх (10±2) дээр байхаар хийнэ. Туршилтын туршид усны түвшинг тогтмол байлгах шаардлагатай. Сорьцоо 24 цагийн дараа уснаас гаргаж аваад 45° налуу торон дээр босоогоор (10±0.5) мин тавьж чөлөөт усыг урсган зайлуулна. Дараа нь сорьцыг жинлээд сорьцын жин m_{24} -г тодорхойлно.

$$W_p = \frac{m_{24} - m_0}{A_p} \quad \text{кг/м}^2$$

m_0 - сорьцын анхны жин, кг

m_{24} - сорьцод 24 цаг ус шингээсний дараах жин, кг

A_p - сорьцын ус шингээсэн гадаргуун талбай, м²

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
даргын 2021 оны 02 дугаар сарын 05-ний өдрийн
1/6.3 тоот тушаалын 4 дүгээр хавсралт



БЕТОН СОРЬЦЫН ШИНЖИЛГЭЭНИЙ СТАНДАРТ АЖЛЫН ЗААВАРЧИЛГАА

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Барилгын салбарт хэрэглэх бүх төрлийн бетонд хамаарна. Бетон сорьцыг статик ачаалалд эвдэлж бетоны шахалтын бат бэхийг тодорхойлох аргыг тогтооно.

2. НОРМАТИВ ИШ ТАТАЛТ

- MNS 1272:1999 Бетон болон бетонон бүтээгдэхүүн. Бетон. Сорьцоор бат бэхийг тодорхойлох арга.

3. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

- STYE-2000, STYE-300 маркийн шахалтын гидро пресс
- 1г-ын нарийвчлалтай жин

4. ТУРШИЛТАД БЭЛТГЭХ

4.1 Сийрмэг бетоноос бусад төрлийн бетонд нэг бүлэгт байх сорьцын тоо 2-оос багагүй байна. Сорьцын гадаргууд үзлэг хийж ан цавтай, ирмэг нь гүнээрээ 10мм-ээс их эмтэрсэн, 5мм-ээс гүн, 10мм-ээс их диаметртэй хонхорхойтой, бетон хольц нь үелсэн буюу дутуу нягтарсан сорьцыг туршилтад оруулахгүй.

4.2 Сорьцыг прессний тавцан дээр байрлуулахын өмнө прессний шахах тавцанг цэвэрлэсэн байна.

5. СОРИЛТ ГҮЙЦЭТГЭХ ДАРААЛАЛ

5.1 Шахалтын прессээ асаана.

1. Асаах улаан товчлуурыг дарна.
2. Measuring товчлуурыг дарж тухайн дээжний баримтын дугаарыг баталгаажуулж 100x100x100мм хэмжээтэй дээжинд 1, 150x150x150мм хэмжээтэй дээжинд 2 гэсэн утгыг оруулан Enter товчлуурыг дарснаар 00 гэсэн утга идэвхжсэний дараа прессний буцах

хавхлагыг түгжиж, шахах талын бариулыг эргүүлснээр 2 тавцан ойртож шахах процесс эхлэнэ.

5.2 Бетон сорьцыг шахах процесс

- Сорьцыг эвдлэх хүчний хэмжээ нь туршилтад хэрэглэх прессний хамгийн их ачааллын 20-80%-ийн хязгаарт багтаж байхаар тооцож прессний хүчний хуваарийг сонгоно.
- Бетон сорьцын тэгш гадаргууг прессний тавцантай харьцах хэсгээр голлуулж байрлуулах ба тасралтгүй, тогтмол хурдтайгаар сорьцыг бүрэн эвдрэх хүртэл ачаална. Ачааллын хурд нь шахалтанд турших үед $0,6 \pm 0,4$ МПа/с хязгаарт байвал зохино. Нэг сорьцыг ачаалах нийт хугацаа нь 30 секундээс багагүй байна.
- Гурван сорьцын шахалтын бат бэхийг үзсэний дараа автоматаар сорилтын үр дүн хэвлэгдэж гарна.

5.3 Туршилтын үр дүнг боловсруулна.

- Сорьц тус бүрийн бетоны бат бэхийг шахалтанд 0.1 МПа нарийвчлалтайгаар дараах томъёогоор тооцно.

f_{α} = сорьцын хэмжээнээс хамааруулан бетоны бат бэхэд зохицуулалт хийх итгэлцүүр
10x10x10см -0,95/

- Сорьцыг шахаж дууссаны дараа үр дүнгийн үзүүлэлтийн баримт нь кN болон МПа гэсэн хэмжих нэгжтэйгээр хэвлэгдэх ба тухайн баримтанд сорьцын хэмжээ, шахсан огноо, цаг минут зэрэг нь тодорхой бичигдсэн байна.
- Уг баримт дээрх үр дүн нь сорьцын хэмжээнээс хамааруулсан итгэлцүүрээр бодогдон, кN-оос МПа гэсэн хэмжих нэгжрүү автоматаар шилжүүлэгдсэн байна.
- Дээрх баримтыг үр дүнг боловсруулахдаа бетоны бат бэхийг бүлэг сорьцын бат бэхийн арифметик дундажаар тодорхойлно. Бүлэгт: 2 сорьц байвал- 2 сорьцын бат бэхийн дундажаар, 3 сорьц байвал – хамгийн их бат бэхтэй 2 сорьцын дундажаар гэсэн зарчмыг баримталж дундаж үзүүлэлтээр нь үр дүнг илэрхийлнэ.



ТООСГОНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ СТАНДАРТ АЖЛЫН ЗААВАРЧИЛГАА

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандарт ажлын зааварчилгаа /САЗ/ нь керамик тоосгоны физик, механик шинж чанарыг тодорхойлоход хамаарна.

2. НОРМАТИВ ИШ ТАТАЛТ

- MNS 0982:1980 Хана, өнгөлгөөний материал. Бат бэхийн хязгаарыг шахалт, гулзайлтанд тодорхойлох арга
- MNS 0983:1980 Хана, өнгөлгөөний материал. Ус шингээлт ба хүйтэн тэсвэрлэлтийг тодорхойлох арга
- MNS 2915:1980 Барилгын материалын дундаж нягт

3. БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

- XMTS-6000 маркийн хатаах шүүгээ
- STYE-2000, STYE-300 маркийн шахалтын гидро пресс
- 1 г-ын нарийвчлалтай жин
- Штангенциркуль
- Томруулдаг шил
- Алчуур
- Гулзайлтанд ашиглах хөдөлгөөнтэй, хөдөлгөөнгүй төмөр тулгуур биет

4. СОРИЛТ ШИНЖИЛГЭЭ

4.1 Дээж бэлтгэх

Сорилт шинжилгээнд нийт 10ш тоосго хэрэглэх ба тоосгоны хэвтээ талд код болон 1-10 хүртэл тоогоор дугаарлан тэмдэглэнэ.

4.2 Жин

Тоосгоны жинг 1 г-ын нарийвчлалтай жин дээр анхны жин буюу хатаахаас өмнөх жинг авна. (m_0)

4.3 Хэмжээ тодорхойлох

Тоосгоны урт, өргөн, зузааныг штангенциркулээр урт, өргөн, зузааны дагуу 3 цэгт хэмжин, хэмжээг тэмдэглэн авч, тус бүрийн арифметик дундажаар тодорхойлно. (a=урт, b=өргөн, c=зузаан).

Шинжилгээнд ашигласан нийт дээжний урт, өргөн, зузааны арифметик дундажийг тооцоолон стандарт хэмжээнээс хасаж хэмжээний зөрүүг олно.

Үзүүлэлт	Стандарт хэмжээ
Урт	250
Өргөн	120
Зузаан	65

4.4 Гадна талын согог, гэмтэл тодорхойлох

Тоосгоны ирмэг, булангийн эмтрэлийн гүнийг 1мм-ийн штангенциркуль эсвэл өнцөг хэмжигч ба төмөр шугамаар өнцөг ба ирмэгийн оройгоос эмтэрсэн гадаргуу хүртэлх эгц босоо зайг хэмжин тодорхойлно.

А. Тоосго бүрийн булан, ирмэгийн эмтрэлийн тоог тэмдэглэн туршилтанд ашигласан сорьцуудын арифметик дундажаар үр дүнг тодорхойлно.

1. Ирмэгийн 3-15мм хүртэл урттай, 15мм-ээс их гүнзгий эмтрэлийн тоо

2. Булангийн 3-15мм хүртэл урттай, 15мм-ээс их гүнтэй эмтрэлийн тоо

Б. Ан цавын тоо: Томруулдаг шил төмөр шугам ашиглан тоосгоны ан цавын тоог тооцоолон туршилтанд ашигласан сорьцуудын арифметик дундаж үр дүнг тодорхойлно.

m ₀	a	Δa	b	Δb	c	Δc	m ₁	Ан цав	Ирмэг		Булан	
									3-5мм	15мм	3-5мм	15 мм
Δ												

4.5 Эзэлхүүний жин (нягт) тодорхойлох

Тогтмол жинтэй болтол нь хатаасан сорьцуудаа 1 г-ын нарийвчлалтай жин дээр жинлэн тэмдэглэнэ. (m) Нийт тоосгоны жингийн арифметик дундаж ба эзэлхүүний арифметик дундажаар эзэлхүүн жинг тодорхойлно.

$$\gamma = \frac{m_{const}}{V}$$

m_{const} – тогтмол жинтэй болтол хатаасан сорьцуудын дундаж жин, кг

V- нийт сорьцуудын эзлэхүүний арифметик дундаж, см³

4.6 Тоосгоны шахалтын бат бэхийг тодорхойлох

Ердийн цул тоосгыг хоёр тэнцүү хэсэгт хувааж тал тоосгыг давхарлан талласан тоосгоны зүсэлтийн гадаргууг харилцан эсрэг чигт байрлуулан шахна. Хоорондоо 200мм-ийн зайтай хөдөлгөөнтэй ба хөдөлгөөнгүй хоёр тулгуур суурь дээр бүтэн тоосгыг байрлуулж, нурууны голд ачааллыг тасралтгүй жигд хурдаар туршилт эхэлснээс 20-60 секундын хугацаанд тоосгыг эвдэлж байхаар тохируулна. Эвдлэх ачааллын хэмжээ нь уг прессийн туйлын ачааллын 10%-иас багагүй байна.

Тэнцүү 2 хуваасан тоосгоны урт (a) өргөний (b) хэмжээг штангенциркулиар хэмжин үзүүлэлтүүдийн арифметик дундажаар үр дүнг тооцоолно.

№	a			Δ	b			Δ	$F_{ш} \text{ см}^2$ $a \cdot b$	$P_{ш}$	$R_{ш} = P_{ш} / F_{ш}$
1											
2											
3											
4											
5											
Δ											

Гулзайлгаж эвдсэн царууц болон цул тоосгыг туршихдаа сорьцыг тэнцүү хуваасан хоёр тал тоосгоор хугалсан амсрыг зөрүүлэн, нүхтэй бол хоёр бүтэн тоосгоор нэгийг нь нөгөө дээр нь давхарлан завсар нь техникийн эсгий эсвэл гадаргууг тэгшилж өгөх нимгэн хавтгай биет хийх, өнгөлгөөний үетэй бетон тоосгыг бүтэн эсвэл тал эдлэхүүнээр сорьц бэлтгэж шахалтын бат бэхийг туршина.

4.7 Шахалтын бат бэхийн хязгаарыг дараах томъёогоор тодорхойлно.

Сорьц бүрийн шахалтын бат бэхийн хязгаарыг $R_{ш} = \frac{P}{F} \times 100$ томъёогоор тодорхойлно.

P-сорьцыг эвдэлсэн ачаалал, Н

F-сорьцын прессний тавцантай харьцсан дээд доод талын талбайн арифметик дундаж талбай. /См²/

Нийт сорьцын дундаж бат бэхийн үзүүлэлтээс 40 хувиас хэтэрсэн бат бэхийн үзүүлэлттэй сорьцыг бат бэхийн дундаж хязгаарыг тооцоход оруулахгүй.

4.8 Ус шингээлт

Тогтмол жинтэй болтол хатаасан 3 сорьцонд туршилт хийх ба 15-20°C-ийн температуртай устай саванд сараалж дээр нэг эгнээгээр хооронд нь 2 см-ээс багагүй зайтайгаар байрлуулна. Сорьцноос дээш усны түвшин 2-10 см байх ба 48 цагийн туршид усанд байлгасны дараа савнаас гаргаад чийгтэй даавуугаар арчиж, тэр даруйд нь 1г-ын нарийвчлалтай жин дээр жинлэх ба энэ үед тоосгоноос жингийн тавцанд унасан усыг дээжийн жинд тооцно.

m	m ₁
1.	
2.	
3.	

Ус шингээлтийг дараах томъёогоор тооцоолно.

$$W_{yc} = \frac{m_1 - m}{m} \times 100 \text{ \%}$$

m₁ - Ус нэвчсэн сорьцын жин, г

m - тогтмол жинтэй болтол хатаасан сорьцын жин, г



ДАЙРГАНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ СТАНДАРТ АЖЛЫН ЗААВАРЧИЛГАА

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандарт ажлын зааварчилгаа /САЗ/ нь дайрганы физик, механик шинж чанарыг тодорхойлоход хамаарна.

2. НОРМАТИВ ИШ ТАТАЛТ

MNS 2998:2009 Барилга, замын ажилд хэрэглэх уулын нягт чулуулаг - хайрга, дайрга. Физик-механик шинж чанарыг тодорхойлох арга.

3. БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

- XMTS-6000 маркийн хатаах шүүгээ
- ZBSX-92 маркийн автомат шигшүүр
- STYE-2000 шахалтын пресс
- 1г, 0,1г, 0.01г-ын нарийвчлалтай жин
- Плунжер
- Ле Шатальен багаж
- Цилиндр
- Алчуур
- Шугам
- Шилэн пипетик

4. СОРИЛТ ГҮЙЦЭТГЭХ ДАРААЛАЛ

4.1 Дээж бэлтгэх

Шинжилгээнд нийт 20-25 кг дайрга хэрэглэгдэнэ.

4.2 Чийглэг тодорхойлох

4.2.1 Дээжийн ширхэглэлээс хамаарч 0.1г-ын нарийвчлалтай жин дээр доорх хүснэгтэнд заасан хэмжээгээр урьдчилан жинлэсэн 2 төмөр саванд сорьц хийж жигнэх ба үлдсэн нийт дээжээ том төмөр саванд хийж бэлтгэнэ.

5-10мм	1.0кг
10-20мм	1.5кг
20-40мм	2.5кг
40-70/80мм	5кг

4.2.2 Бэлтгэсэн дээжүүдээ хатаах шүүгээнд хийж асаах Он улаан товчлуурыг дарж градусыг $105 \pm 5^\circ\text{C}$ / тохируулан high temperature товчлуурыг ажиллуулна. Нэг хатаахдаа 1 цагаас багагүй хугацаанд хатаах ба 45 минутаас багагүй хугацаанд хөргөн тогтмол жинтэй болтол хатаана. Сүүлчийн 2 жинлэлтийн зөрүү нь 0.1 хувиас ихгүй болтол хатаана.

	m /г/	m_1 /г/
1.		
2.		

4.2.3 Хайрга, дайрганы чийглэг (W) дараах томъёогоор тодорхойлж жингийн %-иар илэрхийлнэ.

$$W = \frac{m - m_1}{m_1} \times 100$$

m - Чийгтэй дээжийн жин, г

m_1 -Хуурай дээжийн жин, г

4.3 Асгаасан нягт тодорхойлох

4.3.1 Хайрга, дайрганы ширхэглэлээс хамааруулан доорх хүснэгтийн дагуу цилиндр саваа сонгон авч 1г-ын нарийвчлалтай жин дээр жинлэнэ. (цилиндр сав $m = \dots\dots$)

Хайрга, дайрганы ширхэглэлийн хэмжээ	Цилиндрийн эзлэхүүн, л	Цилиндрийн дотор хэмжээ, мм
5-10мм	5	185
10-20мм	10	234
20-40мм	20	294
40мм-ээс дээш	50	400

4.3.2 Хоёр удаа туршилт хийх ба тодорхойлох бүрдээ шинээр сорьц аван 2 туршилтын арифметик дундажаар үр дүнг тооцно. Урьдчилан жинлэсэн цилиндр саванд хайрга, дайргыг 10см-ийн өндрөөс асгаж, овойлсон хэсгийг төмөр шугамаар нягтруулалгүйгээр, өөр лүүгээ татах буюу голоос хоёр тийш нь хусаж савны ирмэгтэй чацуулан тэгшилж цилиндрт хийсэн хайрга, дайргаа жинлэн авч тэмдэглэнэ.

m_1 , /г/	m /г/
1.	
2.	

4.3.3 Асгаасан нягт (ρ_d)-ыг дараах томъёогоор тодорхойлж $\text{кг}/\text{м}^3$ -аар илэрхийлнэ.

$$\rho_d = \frac{m_1 - m}{V}$$

m_1 -дайргатай цилиндрийн жин, кг

Үүнд: m -Цилиндр савны жин, кг

V - Цилиндрийн эзлэхүүн, м^3

4.4 Ширхэглэлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох

4.4.1 Тогтмол жинтэй болтол хатаасан дээжний ширхэглэлийн хэмжээнээс хамааруулан дараах хэмжээний голч бүхий нүхтэй шигшүүрүүдийг хамгийн бага нүхтэйгээс эхлэн дээш давхарлан /5мм, 10мм, 20мм, 40мм/ 1г-ын нарийвчлалтай лабораторийн жин дээр

Хайрга, дайрганы ширхэгийн хамгийн том хэмжээ, /мм/	Дээжийн жин, /кг/
10	5
20	10
40	20

дээрх хүснэгтэнд заасны дагуу дээж авч туршилтыг гүйцэтгэх ба автомат шигшүүр дээр байрлуулж Оп товчлуурыг дарж 60 секундын турш шигшинэ.

4.4.2 Шигшиж дууссаны дараа шигшүүр бүр дээрх үлдэцийг тус бүрд нь сайн буулгаж урьдчилан жинлэсэн төмөр саванд хийн 1г-ын нарийвчлалтай жин дээр жинлэж хүснэгтийн дагуу бичнэ.

Шигшүүр	I гр	II гр	Δ гр	Үлдэц, %	Нийлбэр үлдэц, %
40мм					
25мм					
20мм					
10мм					
5мм					
<5мм					

Шигшүүр бүр дээрх хэсгийн үлдэц (a_i)-ийг дараах томъёогоор тодорхойлж %-иар илэрхийлнэ.

$$a_i = \frac{m_i}{m} \times 100\%$$

m_i - тухайн шигшүүр дээрх үлдэцийн жин, г

m - дээжийн жин, г

4.5 Бутрамтгай чанарыг тодорхойлох

Зэрэгцээ 2 туршилт хийх ба 2 үзүүлэлтийн арифметик дундажаар үр дүнг тодорхойлно.

4.5.1 Хамгийн бага /d/ ширхэглэлийн хэмжээний нүхтэй шигшүүр дээр үлдсэн хэсгийг 150 мм-ийг голчтой цилиндрт 4 кг-аас багагүй дээж тус бүр хоёрыг бэлдэж 50мм-ийн өндрөөс асгаж тэгшилсний дараа дээжийн дээд түвшин цилиндрийн дээд ирмэгээс 15мм орчим дор байхаар тохируулан плунжерийн хавтангийн дээд ирмэгийг цилиндрийн дээд ирмэгтэй чацуу байхаар тавина.

4.5.2 Хэрвээ хавтангийн дээд ирмэг плунжерийн дээд ирмэгтэй чацуу болохгүй байвал хэдэн ширхэг дайрга нэмэх буюу хасаж өгнө.

4.5.3 Прессээ асааж плунжертэй дээжээ пресст байрлуулан цилиндрийн голчоос хамааруулан прессний шахалтын хүчийг секундэд 1-2kN хурдтайгаар 200kN хүртэл шахна.

4.5.4 Шахсаны дараа урьдчилан жинлэсэн төмөр саванд дээжийг плунжерээс асгаж жинлэн ($m=.$) ширхэглэлийн хэмжээнээс хамааруулж шигшинэ. Үүнд:

5-10 мм-ийн ширхэглэлтэй дайргыг 1.25 мм-ийн нүхтэй шигшүүрээр,

10-20 мм-ийн ширхэглэлтэй дайргыг 2.5 мм-ийн нүхтэй шигшүүрээр,

20-40 мм-ийн ширхэглэлтэй дайргыг 5.0 мм-ийн нүхтэй шигшүүрүүдийг хэрэглэнэ.

Шигшүүр дээрх үлдсэн хайрга, дайргыг 1г-ын нарийвчлалтай жин дээр жинлэнэ. ($m_1=.$)

$m, /г/$ $m_1, /г/$
1.

2.

4.5.5 Бутрамтгай чанар Бу-ыг дараах томъёогоор 1%-ийн нарийвчлалтайгаар тодорхойлно.

$$Bu = \frac{m - m_1}{m} \times 100$$

Энд: m - плунжерт хийж бутласан сорьцын жин, г
 m_1 - хяналтын шигшүүр дээр үлдсэн сорьцын жин, г

4.6 Хурдавчилсан аргаар нягтыг тодорхойлох /Ле Шатальен/

4.6.1 Туршилтанд зориулж ширхэглэл тус бүрээс дор дурдсанаас багагүй хэмжээтэй дээж бэлтгэнэ. 5-10мм-ийн ширхэглэлтэй дайргыг 1кг, 10-20мм-ийн ширхэглэлтэй дайргыг 1.5кг, 20-40мм-ийн ширхэглэлтэй дайргыг 2.5кг дээжийг бэлтгэн чулуулгийн хагархай буюу ширхэгүүдийг тоосыг төмөр сойзоор цэвэрлээд лабораторийн бутлуураар 5мм-ээс жижиг ширхэгтэй болгон буталсаны дараа сайтар хутгаж 150г хүртэл хураангуйлна.

4.6.2 Хураангуйлсан дээжээ 1.25мм-ээс томгүй болтол нунтаглаж холисоны дараа дахин 30г хүртэл хураангуйлж шаазан ууранд 0.125мм-ээс жижиг ширхэгтэй болтол нунтаглаад шаазан аяганд хийж тогтмол жинтэй болтол хатаана.

4.6.3 Хатаасан дээжээ хөргөөд 50г-ын хэмжээтэй 2 сорьц жинлэж авна.

4.6.4 Ле Шатальен багажны доод талын тэмдэглэгээ хүртэл ус хийнэ. Усны түвшинг менискийн доод талаар авна. Сорьцыг зориулалтын төмөр халбага ашиглан багажны амсрын цоргоор бага багаар хийн, багажин дахь усны түвшин 20мл-ийн зураас хүргэхгүйгээр, дээд хэсгийн бусад хуваарьт байхаар хийнэ. Агаарын бөмбөлгүүдийг гаргах үүднээс багажийг бага зэрэг сэгсрэх хэрэгтэй.

4.6.5 Багажинд ороогүй үлдсэн сорьцыг жинлэж тэмдэглэнэ.

	$m, \text{г/г}$	$m_1 \text{ г/г}$
1.	50	
2.	50	

4.6.6 Нягт ρ -ыг дараах томъёогоор тодорхойлж г/см^3 -аар илэрхийлнэ.

$$\rho = \frac{m - m_1}{V}$$

Үүнд: m - Хатаасан нунтаг сорьцын жин, г m_1 -Багажинд ороогүй үлдсэн сорьцын жин, г
 V -Нунтагаар түрэгдэн гарсан усны эзлэхүүн, см^3 /багажны заалтаар авна/

Зэрэгцээ 2 үзүүлэлтийн зөрүү 0.02г/см^3 -аас илүүгүй байна. Хэрвээ үүнээс их зөрүүтэй гарвал 3 дахь үзүүлэлтийг туршиж ойролцоо хоёр үзүүлэлтийг сонгон арифметик дундажаар нь туршилтын үр дүнг тооцно.

4.7 Нимгэн үзүүрлэг хэлбэртэй ширхэглэлийн хэмжээг нүдэн баримжаагаар ялгах арга

4.7.1 Хайрга, дайрган дахь нимгэн, үзүүрлэг хэлбэртэй ширхэглэлийн хэмжээг зузаан нь уртаасаа 3 ба түүнээс олон дахин бага ширхэглэлийн тоогоор үнэлнэ. Ширхэглэл тус бүрээс доорх хэмжээгээр дээж авна.

5-10мм	0.25кг
10-20мм	1.0кг
20-40мм	5кг
40мм-ээс том	10кг

4.7.2 Жинлэсэн дээжээс зузаан нь уртаасаа 3 ба түүнээс олон дахин бага ширхэгүүдийг мөн зузаан ба урт нь мэдэгдэхүйц зөрүүтэй ширхэгүүдийг шууд ялгаж авсны дараа бусад ширхэгүүдийн хэмжээний харьцааг штангенциркулиар хэмжиж ялгана. Ялгасан нимгэн үзүүрлэг ширхэгүүдийг жинлэнэ.

$$Hy = \frac{m_1}{m} \times 100$$

Энд: m -шинжилгээний дээжийн жин, г